

АГУУЛГА

Нэг. Ерөнхий тойм

Хоёр. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа

- 2.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хийсэн ажил
- 2.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн
- 2.3 Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд санал өгөх талаар
- 2.4 Удирдлага, зохион байгуулалтын хийж хүрээнд хийсэн ажил
- 2.5 Бусад байгууллагатай хамтран ажиллах хүрээнд
- 2.6 Хүний нөөцийн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.7 Сургалтын ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.8 Санхүү төлөвлөлт, аж ахуйн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.9 Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.10 Мэдээллийн технологийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.11 Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.12 Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах сурталчилах ажлын хүрээнд

Гурав. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа

- 3.1 Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.2 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.3 Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.4 Бичиг баримтжуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.5 Улсын бүртгэлийн архивын ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Дөрөв. Нөхөн сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Тав. Ковид-19 цар тахлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Зургаа. Бэлэн байдлын үзлэг зохион байгуулах чиглэлээр

Долоо. Шинэ хороо байгуулах ажлын хүрээнд

Найм. Улсын бүртгэлийн нэг цэг байгуулах ажлын хүрээнд

Ес. Бусад ажлын чиглэлээр

Арав. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

НИЙСЛЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ТОЙМ

Нийслэлийн улсын бүртгэлийн газар нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрөөс явуулж буй бүртгэлийн талаарх бодлого чиглэл, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хуульд заасан улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх гэсэн 2 үндсэн чиг үүргийн хүрээнд Газрын дарга, Захиргаа удирдлагын хэлтэс /11/, Харилцагчийн үйлчилгээний хэлтэс /4/, Архивын хэлтэс /9/, Дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс /385/ гэсэн нэгжүүдтэйгээр нийт 410 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын 1.539.252 /нэг сая таван зуун гучин есөн мянга хоёр зуун тавин хоёр/ гаруй оршин суугчдад төрөөс явуулж буй улсын бүртгэлийн талаарх бодлого шийдвэрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж өөрийн харьяа 225 нэгжээс (нийслэл, 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн 6 төв, 5 Улсын бүртгэлийн нэг цэг, 204 хороо) Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. Өөрөөр хэлбэл 2021 онд нийслэлийн хэмжээнд 187 нэгжээс бүртгэлийн үйлчилгээ үзүүлдэг байсан бол 2022 онд 225 болж бүртгэлийн үйлчилгээний үзүүлэх цар хүрээг улам нэмэгдүүлж иргэд, хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг ойртуулан төвлөрлийг багасган ажиллалаа.

2.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Тус газар нь “Алсын хараа-2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.2.2 хэсгийн хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна.

Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар эцэслэн баталж, 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт “Иргэний үнэмлэхийг тоон гарын үсгийн хэрэгслээр ашиглаж болох бөгөөд энэ хуулийн 8.3-т заасан мэдээллийг түүний санах ойд байршуулна” гэж заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн тоон гарын үсэг олгох ажлыг нийслэлийн хэмжээнд дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтэс, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр олгохоос гадна Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын 2022 оны 5 дугаар сарын 22-ны 1/2677 тоот чиглэлийн 3-т дурьдсан “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэн хууль сахиулах байгууллагын албан хаагчид, төрийн байгууллагын албан хаагчид болон дүүргүүдийн нутаг дэвсгэрт байрлах аж ахуй нэгж байгууллагуудад тоон гарын үсэг олгох үйл ажиллагааг хуваарийн дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд нийт 122215 хүсэлт ирүүлснээс 97166 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.



2.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн:

Энэ оны байдлаар Засгийн газрын 2 тогтоолын 2 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 1 заалт, нийт 3 шийдвэрийн 3 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлангийн хугацаанд **Улсын бүртгэлийн ерөнхий газраас:** Хүний нөөцтэй холбоотой 275 тушаал, үүрэг, чиглэл 26, **Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас:** Нийслэлийн Засаг даргын захирамж-5, Чиглэл 8, Зөвлөмж 3, **Нийслэлийн онцгой комиссоос:** үүрэг чиглэл 3, хурлын тэмдэглэл 3, тушаал 1, зөвлөмж 2 тус тус ирснийг хяналтанд авч, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Мөн “Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн нэгдсэн сан” буюу “L-Monitoring” програмд тавигдсан Нийслэлийн Засаг даргын 6 захирамжийн 6 заалт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 4 хуралдааны тэмдэглэлийн 19 заалт буюу нийт 25 заалтыг

хяналтанд авч гүйцэтгэл, үр дүнг 1, 2, 3 дугаар улирлын байдлаар цаг хугацаанд нь тайлагнаж ажилласан.

2.3 Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд санал өгөх талаар:

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн бусад байгууллагаас санал авахаар ирүүлсэн 36 хууль, дүрэм, журмын төслийг албан хаагчдад танилцуулж, саналыг холбогдох газруудад хүргүүлсэн байна.

2.5 Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралд 3, шуурхай хуралдаанд 17, холбогдох ажлын хэсгүүдийн хурал, мөн Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаанд 24 удаа, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тухай бүр тус тус оролцож, өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд газрын удирдах албан хаагчдын шуурхай хуралдааныг 18 удаа зохион байгуулж, хурлаас нийт 207 үүрэг даалгавар өгч, биелэлтийг гарган ажиллаж байна.

Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын даргын 100 тушаал, 8 гэрээний төслийг боловсруулж, батлав.

Тус газрын Захиргаа удирдлагын хэлтсээс 3, Харилцагчийн үйлчилгээний хэлтсээс 3, Архивын хэлтсээс 2 чиглэл нийт 8 удаагийн чиглэл боловсруулан хүргүүлсэн.

Тус газар нь 2022 онд 146 төрлийн тайлан, мэдээг давхардсан тоогоор 315 удаа холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна.

2.5 Бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр:

Тус газар нь 2022 онд өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн халамжийн газар, Нийгмийн даатгалын газар, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Гэр бүл хүүхэд залуучуудын газар”, “Хотын засаглалыг сайжруулах” төсөл, бүх шатны ерөнхий боловсролын сургуулиуд, хууль хяналтын болон холбогдох төрийн бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Гэрэгэ системс” ХХК, “Улаанбаатар Буян” ХХК “Азийн хөгжлийн сан”, “Монгол Шуудан” ХХК, “Дэлхийн Зөн” олон улсын байгууллага, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, “Голомт банк”, “Төрийн банк”, “Богд банк”, “Хаан банк” зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан.



Нийслэлийн улсын бүртгэлийн газар:

1. Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, цахим сүлжээний хэвийн ажиллагааг хангах, мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан төрийн үйлчилгээ, лавлагааг орон зай, цаг хугацаанаас үл хамааран иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, төрийн ой санамжийг бий болгох,

түүнд суурилсан бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд төрийн үйлчилгээ үзүүлэх цахим машин шийдвэрлүүлэх саналыг Нийслэлийн Засаг даргад хүргүүлснээр Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд 12 ширхэг улсын бүртгэлийн цахим машин, 3 ширхэг зөөврийн тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлэн 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авах мэдэгдэл хүлээн авсан.



2. “Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан баррель үсэг бүхий гарын авлагын эхийг бэлтгэн 200 ширхэгийг хэвлүүлэн хэлтэс, нэгжүүдэд хүргүүлсэн.



3. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний 12/36 дугаар "Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай" тогтоолын дагуу Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт шинээр 33 хороо байгуулагдахаар болсон. Үүнтэй холбоотойгоор иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор шинээр байгуулагдсан 33 хорооны төрийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах, иргэдийн хаягийн мэдээлэл, хуулийн этгээдийн болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлыг зохион байгуулахтай холбоотой зардлын тооцоог гарган Нийслэлийн Засаг даргын А/261 дугаар “Засаг захиргааны анхан шатны нэгж хороо байгуулагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” захирамжийг 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдөр гаргуулсан.

Нийслэлийн засаг даргын А/261 дугаар захирамжийн дагуу шинээр байгуулагдаж байгаа 33 хороонд 39,250,000.00 төгрөгийн тавилга, эд хогшил, 334,420,900 төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч дүүргүүдэд хувиарласан.



Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай дараах байдлаар хамтран ажилласан байна. Үүнд:

Багануур дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь:

Дүүрэг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 23 сая төгрөгийн өртөг бүхий улсын бүртгэлийн 1 ширхэг цахим машиныг шийдвэрлүүлсэн.

Багахангай дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 өрөөнд буюу нийт 140 м2 талбайд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна. Дүүргийн удирдлагуудад архивын өрөө, бусад өрөө тасалгаа шаардлагатай байгаа талаар албан бичиг хүргүүлсэн.
2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран Хангай цогцолбор сургуулийн 37 сурагчдыг хамруулсан “Иргэний андгай өргөх” ёслолыг Төрийн ордонд зохион байгуулсан. Нийт өртөг 1 500 000 төгрөг

Баянгол дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Дүүргийн Засаг даргын дэмжлэгээр улсын бүртгэлийн 2 ширхэг цахим машиныг шийдвэрлүүлж ажилласан.
2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэмжлэгээр 2 хороонд цахим төлбөрийн пос машиныг шийдвэрлүүлсэн.

Баянзүрх дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Баянзүрх дүүргийн Төр захиргааны II байр, “Жанжин клуб”, “Дарь-эх” үйлчилгээний танхим болон өрөөний тохижилт, тавилга, өрөөний тусгаарлах шилэн хаалт, засвар үйлчилгээнд 42 сая төгрөгийн зардлыг дүүргийн Засаг даргын Тамгын газраар шийдүүлсэн байна.
2. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 7 сая төгрөг шийдүүлж, хэлтсийн засвар үйлчилгээний танхим, өрөө тасалгаанд засвар хийн, үйлчилгээний цонхны тавилгыг стандартын дагуу намсгаж завсарласан.
3. Хэлтсийн үйлчилгээний танхим, Дарь-Эх нэг цэгийн үйлчилгээний танхимд хүлээлгийн сандалыг шинэчлэн 12 сая төгрөгийн 12 сандал хүлээн авсан.
4. Дүүргийн Засаг даргын Тамгын газраар тус хэлтсийн иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээнд ашиглах иж бүрэн 3 компьютер буюу 6 саяын үнэ бүхий тоног төхөөрөмж шийдвэрлүүлсэн.

5. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас улсын бүртгэлийн 4 ширхэг цахим машин, 1 явуулын машиныг худалдан авах тендерт оролцож “Хазаарбат” ХХК шалгарч **126.880,000** сая төгрөгийг төсөвт суулгасан байна.
6. Баянзүрх дүүргийн төр захиргааны II байрны улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээний шилэн кабелийн үнэ 6 сая төгрөгийг тус тус шийдүүлж нийт 199,880,000 төгрөгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, тавилга, эд хогшил шийдвэрлүүлсэн байна.

Налайх дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. “Гэрэгэ” ХХК-тай хамтран киоск машиныг алслагдсан 5,6 дугаар хороонд нэмж байршуулсан.

Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, албан хаагчдын ажлын байрны нөхцөлийг сайжруулж дүүргийн Нутгийн захиргааны нэгдсэн байрны 1,2-р давхарт үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хорооны Засаг дарга нартай хамтарч 23 хорооны улсын бүртгэгчийн ажиллах орчин нөхцлийг сайжруулж бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх өрөө тасалгаатай болгосон.
2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Засаг даргын Тамгын газартай хамтран цахим төлбөрийн “Гэрэгэ киоск” 4 ширхэгийг шийдвэрлүүлсэн. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Засаг даргын Тамгын газартай хамтран төлбөр тооцооны пос машин 5 ширхэг шийдвэрлүүлэн ажилласан.
3. Улсын бүртгэлийн 1 ширхэг цахим машин тус тус шийдвэрлүүлсэн.

Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2022 оны А/167 дугаар захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх ажлыг зохион байгуулж уг ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх өрөөг бэлтгэн тохижуулж хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн эхчүүд, өндөр настан иргэдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.
2. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгөөр дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст цахим төлбөрийн 15 пос машин шийдвэрлүүлэн үйлчилгээний хураамжийг иргэн, хуулийн этгээдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үзүүлж байна.

Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 20 сая төгрөгийн санхүүжилт гарган тус хэлтсийн албан хаагчдын байрлаж буй 2 давхарын улсын бүртгэлийн хэлтсийн өрөө тасалгаанд засварын ажил хийсэн.
2. Өрөө тасалгааны багтаамжийг 6мк2 -аар нэмэгдүүллээ.
3. Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чанартай хүргэх ажлын хүрээнд 21 хороонд Хан-Уул дүүргийн засаг даргын Тамгын газраас

73.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн “Гэрэгэ киоск” төлбөрийн машиныг суурилууллаа.

4. Хэлтсийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх зорилгоор Хан-Уул дүүргийн 2022 оны орон нутгийн төсөвт 75 сая төгрөгийн санхүүжилтийг суулгуулж, 2022 оны 7 дугаар сард Засаг даргын Тамгын газраас тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж 10 ширхэг иж бүрэн компьютер, 2 ширхэг том хувилагч, 8 ширхэг 3 үйлдэлт принтер, 8 ширхэг скайнер шийдвэрлүүллээ.
5. Улсын бүртгэлийг иргэдэд хүртээмжтэй хүргэх, төвлөрлийг сааруулах зорилгоор 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс Буянт-Ухаа олон улсын нисэх буудалд “Нэг цэгийн үйлчилгээ”-г нээн ажиллуулж эхэлсэн. Уг төвийн тохижилтын ажилд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас 7.5 сая төгрөгийн санхүүжилт хийж хамтран ажиллалаа.

Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар нэг цонхны үйлчилгээний байрны засвар оруулж иргэдэд орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, тав тухтай орчноос улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.
2. Дүүргийн санхүүжилтээр 33,000,000 сая төгрөгөөр бүх хороонд буюу 25 ширхэг цахим төлбөрийн пос машинтай болгосон.

2.6. Хүний нөөцийн чиглэлээр:

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон албан хаагчийг томилох, тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.

2022 онд шинэчлэн гаргасан 357 албан хаагчдын ХАСХОМ-ын мэдүүлгийг хүлээн авч, цахим системд баталгаажуулан, Улсын бүртгэлийн ерөнхий газарт тайлан мэдээ хүргүүлсэн. Мэдүүлэг гаргахаас татгалзсан болон хугацаа хоцроож мэдүүлсэн албан хаагч байхгүй. Шинээр томилогдсон 99, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн 17 албан хаагчийн 2021 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч, цахим системд баталгаажуулсан байна.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинээр томилогдсон 132 албан хаагчаас “Нууцын баталгаа”-г гаргуулан авсан. Орон нутгийн сонгуулиар ажиллах Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн саналын дагуу 5 итгэмжлэгдсэн ажилтан томилох тухай тушаалыг гаргаж, нууцын баталгаа гаргуулсан. Нийт 137 албан хаагчаас “Нууцын баталгаа” гаргуулсан.

Хүний нөөцийн чиглэлээр 29 төрлийн судалгааг гарган удирдлагад танилцуулж, холбогдох газарт хүргүүлсэн байна. Судалгаанд давхардсан тоогоор 3200 орчим хүн хамрагдсан байна.

Төрийн үйлчилгээний 5 албан хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийсэн.

Тус газрын албан хаагчдын 2021 оны гүйцэтгэлийн тайланг үнэлсэн үнэлгээний хуудсыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын хүний нөөцийн програмд оруулж цахимжуулсан. Нийт 362 албан хаагчийн 1810 хуудас бүхий материалыг цахимжуулсан байна.

Албан хаагчдын орж гарсан хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, систем ашиглан цалин бодогдож байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхээр газрын даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 9 дүүргийн албан хаагчдын ажлын байрын зураг авалтыг 2022.06.07-06.09-ний хооронд хийж гүйцэтгэн тайланг танилцуулсан.

Төрийн албаны зөвлөлийн аудитын багийн шаардсан 12 төрлийн судалгаа, тоон мэдээг Тамгын газрын даргын үүрэг болгосны дагуу хугацаанд нь гаргаж өгч мэдээ мэдээллээр хангасан.

Монгол Улсад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан тус газрын албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ирцийн байдалд хяналт тавих, албан хаагч ажил тасалсан, хожимдсон тохиолдолд түүнд ажилласан хугацааны цалинг тооцож олгох зорилгоор цаг бүртгэлийн цахим програмыг нэвтрүүлэн турших ажлыг эхлүүлэн газрын даргын А/12 дугаар тушаалаар албажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, 9 дүүргийн Засаг дарга нартай уулзаж санал хүсэлт солилцсоны үр дүнд Багахангай дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Ц.Одгэрэлийг “Түрээслээд өмчлөх нөхцөлтэй”-гөөр, Багахангай дүүргийн 1 дүгээр хорооны 1 дүгээр байранд 4 өрөө 74,8м2 орон сууцанд оруулсан.

Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан 13 дугаар хорооны улсын бүртгэгч Н.Энхтуул, 16 дугаар хорооны улсын бүртгэгч Ж.Наранцэцэг нарт 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр өргөө цагаан гэр олгож, батламжийг гардуулан өгч, 2 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн.



Тус газраас ар гэрийн гачигдал гарсан 13 албан хаагчид газрын даргын тушаалаар нэг удаагийн мөнгөн тусламж олгосон.

2022 оны 3 дугаар сард 2021 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээг үндэслэн Б/14 дүгээр тушаалаар 457 албан хаагчийн цалингийн шатлал, төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл ахих болзол хангасан зарим албан хаагчийн нэмэгдлийг шинэчлэн тогтоосон.

Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын дагуу 2022 оны 6 дугаар сард төрийн үйлчилгээний 42 албан хаагчийн цалинг шинэчилсэн.

2022 оны 6, 11 дүгээр саруудад албан хаагчийн 2022 оны хагас, бүтэн жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний баг ажиллуулах тус газрын даргын А/14, А26 дугаар тушаалын дагуу албан хаагчдын ажлыг үнэлж мөнгөн урамшуулал олгосон.


2.7 Сургалтын ажлын хүрээнд:

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан “Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын сургалтын төлөвлөгөө”-г баталж, **235** удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор **8177** ажилтан, албан хаагч хамруулсан. Үүнд:

- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газраас-84 удаагийн сургалтаар-3247
- ❖ Нийслэлийн улсын бүртгэлийн газраас-29 удаагийн сургалтаар-868
- ❖ Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүд-49 удаагийн сургалтаар-1370
- ❖ Бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан-73

удаагийн сургалтанд 2692 ажилтан, албан хаагчдыг хамруулсан байна.

Иргэдэд зориулсан эрх зүйн сургалтын хүрээнд: Тайлангийн хугацаанд дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон төрийн, төрийн бус байгууллагуудад **79** удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор **19745** харилцагчид улсын бүртгэлийн хууль тогтоомж, цахим гарын үсгийн тухай хуулийг сурталчилсан байна.



2021 оны мөн үетэй харьцуулбал сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо 2 дахин өсч, сургалт явуулах арга хэлбэрийг улам боловсронгуй болгож нийт сургалтын ихэнх хувийг цахимаар зохион байгуулсан байна.

2.8 Санхүү, аж ахуйн чиглэлээр:

Газрын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Олон улсын стандартад нийцүүлэн батлагдсан маягт зааврын дагуу хөтлөх, газрын болон дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- ❖ Байгууллагын 1,2,3-р улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.
- ❖ Нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг тус тус хугацаанд нь хүргүүлж өр төлбөргүй ажилласан.

- ❖ Санхүүгийн тайлангийн 2021 оны аудитыг Мишээл-Од аудит ХХК-аар хийлгэж ЗӨРЧИЛГҮЙ дүгнэлт авсан. Тайланд өгсөн зөвлөмжийн мөрөөр хийсэн ажлын тайлан гаргаж эхний хагас жилд багтаан нийслэлийн төрийн аудитыг газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод аудитад хүргүүлсэн.
- ❖ Шилэн дансанд 11 удаагийн 133 мэдээллийг байршуулсан.
- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газрын тайлан, мэдээ гаргах журмын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлан, өр авлагын мэдээг сар бүр хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдалгүй ханган ажиллах хүрээнд:

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг үр бүтээлтэй зарцуулах, хуваарилах, төлөвлөх ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд төсөв хэтрээгүй.

Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах санал 5 удаа хүргүүлж ажилласан. Гэвч төсвийн хуваарийн дагуу эрх нээгдүүлээгүйгээс шалтгаалан байрны түрээс, дулаан ашиглалтын зардалд өр үүссэн.

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг тогтмол төвлөрүүлсэн.

2022 оны 11 дүгээр сарын байдлаар дараах орлогыг төвлөрүүлэн ажилласан байна.

д/ д	Хугацаа	Орлого, зардлын зүйл анги	Үйлчилгээний төрөл	Мөнгөн дүн /өссөн дүнгээр/
1	2022 оны 11 дүгээр сарын байдлаар	Улсын төсөвт	Үйлчилгээний орлого	9,9 тэрбум
2		Орон нутгийн төсөв	Торгууль шийтгэврийн орлого	1 тэр бум
			Тэмдэгтийн хураамж	2,1 тэрбум
			Үл хөдлөх хөрөнгийн татвар	50,5 тэрбум

Үндсэн хөрөнгө, бараа материалын орлогыг үнэн зөв хүлээн авч зарцуулалтанд хяналт тавьж ажиллалаа.

Үндсэн хөрөнгийн орлого: Улсын бүртгэлийн ерөнхий газраас 5 нэр төрлийн 16 ширхэг 74,6 сая төгрөгийн өртөгтэй 15.7 сая төгрөгийн элэгдэлтэй машин тоног төхөөрөмж, 3 нэр төрлийн 15 ширхэг 3.0 сая төгрөгийн өртөгтэй, 407.8 төгрөгийн элэгдэлтэй тавилга эд хогшлыг хүлээн авч, дүүргүүдэд хуваарилсан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02-р сарын 24-ны өдрийн 261 дугаар захирамжийн дагуу шинээр байгуулагдсан 33 хороонд 9 нэр төрлийн 278 ширхэг 373,7 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэлийг тендер зарлан шалгаруулж худалдан авсан.

Хан-Уул дүүргийн засаг даргын тамгын газрын санхүүжилтээр 3 нэр төрлийн 28 ширхэг 69,6 сая төгрөг компьютер принтер, скайнерийг хүлээн авч холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн бүртгэлд тусгасан.

2021 оны аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газраар шийдвэр гаргуулан 3 нэр төрлийн 16 ширхэг 44.594.000 төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалаас үндсэн хөрөнгө рүү шилжүүлж бүртгэлд тусган дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүдэд хувиарласан.

2021 оны жилийн эцсийн тооллогын үр дүнг гарган цаашид ашиглах боломжгүй Нийслэлийн улсын бүртгэлийн газар нь 1224 ширхэг 168.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж орлогод авч үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 3 нэр төрлийн 29 ширхэг 49.614.000 төгрөгийн үндсэн хөрөнгийг өмч хамгааллын байнгын зөвлөлийн хяналтанд актлаж устгасан

Тус газар болон дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст ашиглаж байсан 395,599,863.28 төгрөгийн машин, тоног төхөөрөмж болон 7,194,717.36 төгрөгийн тавилга эд хогшил, 737,000.00 төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2022 оны А/308 дугаар тушаалыг үндэслэн данснаас хасаж акталж устгасан.

Мөн Нийслэлийн Засаг Даргын захирамжийн дагуу Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст ашиглагдаж байсан Sonata маркийн машиныг 2022 оны 7 дугаар сард Нийслэлийн авто тээврийн газарт хүлээлгэн өгсөн.

Орлого/ бараа материал/

Улсын бүртгэлийн ерөнхий газар	Урсгал төсөв	Нэмэлт санхүүжилт
138 нэр төрлийн 561092 ширхэг 279,7 сая төгрөг	488 нэр төрлийн 98259 ширхэг 300,8 сая төгрөг	Сонгуулийн зардалд 2,3 сая төгрөг , Шинээр байгуулагдсан хорооны иргэдийн бичиг баримтыг шинэчилэхэд НЗД-ийн захирамжаар 519759 ширхэг 2692,2 сая төгрөгийн үнэт цаас, бусад материал орлогод авсан.

Зарцуулалт, хуваарилсан /бараа, материал/

Акталж ашиглалтаас хассан	Үйл ажиллагаанд	Сонгуулийн зардалд	Бусад дотоодод шилжүүлсэн
466 ширхэг 453,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө актласан.	626 нэр төрлийн 850835 ширхэг 647,5 сая төгрөг зарцуулсан	Нөхөн сонгуульд 2,3 сая төгрөг зарцуулсан. Шинээр байгуулагдсан хорооны иргэдийн бичиг баримтыг шинэчилэхэд 100,0 сая төгрөгийн улсын бүртгэлийн маягт, бусад материал зарцуулсан.	626 нэр төрлийн 850835 ширхэг 647,5 сая төгрөгийг дотоод гүйлгээгээр шилжүүлсэн. Шинээр байгуулагдсан хорооны иргэдийн бичиг баримтыг шинэчилэхэд УБЕГ-т 324000 ширхэг 2592,2 сая төгрөгийн үнэт цаас хоорондын тооцоогоор шилжүүлсэн.

Ажилчин албан хаагчдын цалин хөлс, урамшуулалыг цаг хугацаанд нь бодож олгож цагийн бүртгэл бусад тооцоололд хяналт тавьж ажиллаа. Итгэмжлэгдсэн

ажилтануудын байгуулсан гэрээний дагуу урамшуулалыг тооцож холбогдох журмын дагуу татвар нийгмийн даатгалын шимтгэл суутган ажилласан.

Үзүүлэлт сая.төг	Батлагдсан төсөв	Нийт төсөв	Олгосон
Цалин хөлс	5569,1	5569,1	5569,1
НДШ	696,2	696,2	696,2
Нийт	6265,3	6265,3	6265,3

Гэрчилгээ, үнэт цаасны зарцуулалтад сар бүр тогтсон хугацаанд хяналт тавин ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 12683 ширхэг үнэт цаас өмч хамгаалах зөвлөлөөр актлах шийдвэр гаргаж данснаас хассан.

Үүнээс 3254 ширхэг нь ажилтны алдаа, 9429 ширхэг нь техникийн алдаа гарсан байна. Алдаа гаргасан ажилтнуудаар 1055521.49 төгрөгийн төлбөрийг бүрэн төлүүлсэн.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу бичиг хэргийн материалын 100.0 сая төгрөгийн тендер, шинээр байгуулагдаж байгаа 33 хорооны компьютер, тоног төхөөрөмжийн 466.2 сая төгрөгийн тендрийг зохион байгуулж, гэрээ байгуулан ажилласан.

Нийслэлийн өмчийн харилцааны газраас ирсэн “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2021 оны биелэлтийг дүгнэж, үнэлэлт өгөх үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамжийн дагуу хийсэн шалгалтанд “Хангалттай” үнэлэгдсэн.

2.9 Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд:

2.9.1 Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Баримт бичгийн шийдвэрлэлт болон бусад мэдээллийн эрэлт хайлтыг шуурхай болгох үүднээс газарт ирсэн баримт бичгийг “Албан хэрэг хөтлөлтийн E-DOC програм”, ABLE програмд бүртгэн цахим санамжид оруулан ажиллалаа.

2022 онд тус газрын хэмжээнд нийт **20936** албан бичиг хүлээн авч edoc програмд бүртгэснээс хариутай бичиг **5076** байна. Дээрх албан бичгээс 12902 албан бичиг нь албан хэрэг хөтлөлтийн edoc систем хэрэглэгч байгууллагад, 5 нь нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд бүртгэгдэж цахим хэлбэрээр ирсэн бол үлдсэн 1453 албан бичгийг байгууллага дээр скайнердаж цахимжуулсан байна. Мөн able програмд нийт **111** албан бичиг бүртгэгдэж шилжүүлэн шийдвэрлэсэн. Нийслэлийн онцгой комиссоос 14, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас **167**, албан бичгийн шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд ирсэн бичгийн шийдвэрлэлт 98.58% байна.

Мөн хугацаанд нийт **103** тушаал /үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 27, хүний нөөцийн чиглэлээр 76/ гарсан байна. Edoc програмд **12626**, able програмд **22** албан бичгийн төслийг холбогдох ажилтнуудаас хүлээн авч, удирдлагаар баталгаажуулан хэвлэмэл хуудсанд буулган албажуулан, нэгдсэн дугаар олгосон. Эдгээрээс Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад архив,

албан хэрэг хөтлөлтийн програмаар илгээж бусад албан бичгүүдийг шуудангаар холбогдох газарт нь хүргүүлсэн.

Албан бичиг шийдвэрлэлтийн дундаж хугацаа: 7 хоног 3 цаг буюу нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлтээс бага байна.

Байгууллагын архивын чиглэлээр:

- ❖ Архивт баримт шилжүүлэх үед хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт хийсэн.
- ❖ Хүлээн авсан хадгаламжийн нэгжид хадгалах хугацааны ангиллаар данс бүртгэл үйлдсэн.
- ❖ Архивын цэвэрлэгээ, үйлчилгээ хуваарийн дагуу тогтмол хийгдэж байна.
- ❖ Байгууллагын архивын чийг, дулааныг өдөр тутам тогтмол хэмжиж, тэмдэглэл хөтөлж байна.
- ❖ Албан хаагчдын албан хэрэгцээнд архивын баримт ашиглуулахдаа бүртгэлийг тогтмол хөтөлж байна.
- ❖ Хэвлэмэл хуудасны тайланг хүлээн авч, хүчингүй болсон хэвлэмэл хуудас байхгүй байна.
- ❖ Газрын 2021 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан батлуулж, 2021 онд хөтлөгдсөн баримт бичгийг Архивын тухай хуулийн дагуу байгууллагын архивт 2022 оны 1 дүгээр улиралд бүрэн хүлээн авсан.
- ❖ 2022 онд байгууллагын архивт байнга хадгалах 33, 70 жил хадгалах 21, түр хадгалах 567 нийт **621** баримт хүлээн авсан байна.

2.9.2 Өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд:

Тус газар нь иргэн, хуулийн этгээдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариу өгөх жишиг тогтоох үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.


2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт **606** өргөдөл, гомдол, хүсэлт, санал ирсэн байна. Үүнд:

- ❖ Гомдол-407
- ❖ Санал, хүсэлт-81
- ❖ Талархал-118




Уг харьцуулалтаас үзэхэд 2022 онд улсын бүртгэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн цахим үйлчилгээ болон төвлөрлийг багасгасан ажлууд нь иргэд, олон нийтийн талархлыг хүлээсэн ажил болсон нь харагдаж байна.


Өргөдөл, хүсэлт, санал, гомдлыг хэлтэс нэгжээр нь ангилж үзвэл:



Өргөдөл, гомдлыг агуулгаар нь харьцуулахад:



Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг ирсэн хэлбэрээр харьцуулахад:



Нийт ирсэн 606 санал хүсэлт, талархал, гомдлын 99 хувь нь шийдвэрлэгдсэн байх бөгөөд судлагдаж байгаа 7 өргөдөл, гомдол байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 13 цаг 32 минут буюу нийслэлийн байгууллагуудын шийдвэрлэлтийн дундаж хугацаанаас бага үзүүлэлттэй байна.

Авч хэрэгжүүлсэн сайжруулалтын арга хэмжээ:

- ❖ Монгол Улсын ерөнхий сайдаас иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирж буй өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар хийсэн мэдээллийг бүх албан хаагчиддаа нэг бүрчлэн танилцуулах үүргийн хүрээнд Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын Тамгын газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн цахим хурал дээр танилцуулсан мэдээллүүдийг 382 албан хаагчдад танилцуулж, танилцуулсан тухай тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулсан. Уг танилцсан тухай тэмдэглэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргад хүргүүлсэн.
- ❖ Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын шуурхай хуралдаанд өргөдөл, гомдлын тоон мэдээ, шийдвэрлэлт болон зөрчлийн талаар 12 удаа

танилцуулга хийсэн бөгөөд газрын даргаас хэлтсийн дарга нарт 9 удаа үүрэг, даалгавар өгч ажилласан.

- ❖ Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлтийг чиг үүргийн дагуу, агуулгын хувьд багцлан зохион байгуулалт, хүний нөөц, сүлжээний тасралтгүй байдлыг хангах зэрэг нийт 24 санал хүсэлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт уламжлав. Мөн иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой 28 санал хүсэлтийг чиглэлийн газруудад хүргүүлэн ажиллалаа.
- ❖ Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлэв.
- ❖ 2022 оны 1, 5, 10 дугаар саруудад Нийслэлийн Улсын бүртгэлийн газарт ирсэн өргөдөл гомдолд нэр дурьдагдсан 46 албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн зөвлөл болон үйлчилгээний стандартын талаарх сургалтыг 3 удаа зохион байгуулж, тодорхой кейсүүд дээр ажиллууллаа.
- ❖ Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааг шалгах шалгалтын удирдамжийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 03 дугаар сарын 18-ны өдрийн хооронд дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт шийдвэрлэлт, зөрчлийг шалган ажилласан.

2.10 Мэдээллийн технологийн чиглэлээр:

Газрын тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, ашиглалтад хяналт тавих, мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.

Тоног төхөөрөмж, програм болон сүлжээний аюулгүй байдлыг тасалдуулахгүй ажиллах хүрээнд тоног төхөөрөмжийн засвар гэмтлийг тухай бүр оношлон шуурхай засварлаж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын системээр хүний нөөцийн удирдлага, утасны жагсаалт, цаг бүртгэл, мэдээ мэдээлэл, ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар, олон нийтийн сүлжээ, тайлан судалгаа, өргөдөл гомдол, үндсэн хөрөнгө бүртгэл, үйл явдал, судалгаа авах, байгууллагын архив, албан хэрэг хөтлөх, дотоод мессенжер зэрэг өргөн боломжтой цогц системийг албан хаагч нарт хандах эрхийг тохируулан ажиллаж байна.

2022 онд Нийслэл болон дүүргүүдэд шаардлагатай байгаа сүлжээний рутер төхөөрөмж, медиа конвертер, сүлжээний толгой, утас зэрэг төхөөрөмжүүдээр ханган 8,324,500 төгрөгийн үнэ бүхий төхөөрөмжийг шийдвэрлэн ажилласан.

Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор ажлын цаг бүртгэлийн цахим програмыг өөрсдийн дотоод нөөц бололцоогоо ашиглан хийсэн.

Уг програм нь компьютер дээр ажиллах болон гар утасны аппликейшн гэсэн 2 хэсгээс бүрдэх бөгөөд гар утасны аппликейшныг Android, Apple системийн гар

утсанд татаж авч болохоор Store-д суулгасан. Хэрэглэгчид уг аппыг татаж авах, ашиглахад ямар нэгэн төлбөр төлөхгүй юм. Утасны програмд нийт албан хаагчдын албан тушаал, утасны дугаарыг байршуулсан ба албан хаагчийн нэр, албан тушаалаар хайлт хийх боломжтой байхаар шийдсэн. Суурин компьютерээс системд нэвтэрч албан хаагчдын ажлын цагаа бүртгүүлсэн байдлыг хянаж, өгсөн хугацааны хязгаараар тайланг эксел файл хэлбэрээр татах боломжтой. Уг эрхийг тус газрын бүх хэлтсийн дарга нарт нээж өгсөн. Програмын ажиллах зарчмыг аль болох энгийн, хэрэглэхэд хялбар байхаар шийдэхийг зорьсон. Ажиллах ерөнхий зарчим:

- Албан хаагчийн ажлын байр нэг бүрийн байршлын уртраг, өргөргийг нарийн тодорхойлж тодорхой радиустай тойрог /цаашид үүр гэх/ үүсгэсэн. Бүх хороо, дүүрэг, нэгдсэн төвүүдийг үүр болгосон бөгөөд шинээр байгуулагдсан Дарь эх, Жанжин, Буянт ухаа салбарыг мөн нэмсэн.
- Албан хаагчийн ажлын цаг бүртгүүлэх цэг буюу үүрийг урьдчилан бүртгэх ажлыг хэлтсийн мэдээллийн технологийн ажилтан эсхүл хүний нөөцийн ажилтан хийнэ. Нэг албан хаагчид хамгийн ихдээ 3 үүр бүртгэх боломжтой.
- Албан хаагч ажлын байрандаа ирээд гар утасны location асааж аппликейшн рүү нэвтрэхэд “Таны байршлыг шалгаж байна” гэсэн мессэжний дараа цаг бүртгүүлэх товч гарч ирснийг дарснаар ирсэн цаг бүртгэгдэнэ. Энэ үйлдлийг явахдаа хийснээр ажилтны тухайн өдрийн ажлын цаг бүрэн бүртгэгдэнэ.

Програмын давуу тал:


- Цаг бүртгэхэд ямар нэгэн тоног төхөөрөмж шаардахгүй.
- Бүх албан хаагчдын цагийг бүртгэх, хянах боломжтой.
- Дотоод нөөц бололцоогоо ашиглан хийсэн тул зардал гараагүй.
- Албан хаагч ажлын байраа өөрчлөх тохиолдолд цаг бүртгэхэд хоцрогдол гарахгүй.
- Бүх албан хаагчийн утасны дугаар, албан тушаалыг байршуулсан.
- Хүний биометрик мэдээллийг ашиглаагүй.
- Өөрсдийн зорилгод нийцүүлэн сайжруулах боломжтой.

Програмын сул тал:

- Хятад улсад үйлдвэрлэсэн зарим төрлийн гар утаснууд, Apple брэндийн 6,6s болон түүнээс өмнөх үеийн гар утсан дээр аппликейшн суудаг боловч, тухайн утасны байршил тогтоох чадвараас шалтгаалж цаг бүртгэж чаддаггүй.

Цаашдын төлөв:

- Одоогийн байдлаар тайлан зөвхөн эксел хэлбэрээр гарч байгааг pdf форматаар гаргах.
- Уг програмыг хийсэн мэдээллийн технологийн ажилтан Б.Эрдэнэтуул өөрийн хүсэлтээр ажлаас гарсан нь уг ажлын цаашдын явцад сөргөөр нөлөөлж байна. Газрын даргын 2022 оны А/12 дугаар тушаалаар ажлын цаг бүртгэлийн цахим програмыг 5 дугаар сараас туршиж эхэлсэн.



2.11 Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах сурталчилах ажлын хүрээнд:

2.11.1 Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал

Байгууллагын ил тод нээлттэй, шуурхай хариуцлагатай байдлыг хангаж, төр иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчилж мэдээлэх, иргэдийн санал бодлыг сонсох, “Нээлттэй хаалганы өдөр”, бүртгэлийн “Ёслолтой арга хэмжээ”, иргэдэд чиглэсэн бусад үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ил тод, нээлттэй, хариуцлагатай, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилтуудыг тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- ❖ Монгол Улсын Засгийн газрын 352 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Нээлттэй мэдээллийн ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу байгууллагын эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл болон байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, төр засгийн бодлого шийдвэртэй холбогдсон мэдээ, мэдээллийг “Мэдээллийн самбар”, цахим дэлгэц, байгууллагын болон хэлтэс нэгжийн цахим хуудас, фэйсбүүк хуудсанд бүрэн байршуулж, мэдээллийг тухай бүрт шинэчлэн ойлгомжтой байдлаар байршуулсан.
- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 21-ний Б/371 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган 2022 оны 7 дугаар сард газар, хэлтсүүдийн гадна хаягийг нэг стандартын дагуу шинээр хийлгэн сольж байршуулсан.
- ❖ Байгууллагын хэмжээнд иргэдийг цагийн хуваарьгүйгээр хүлээн авч, санал хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна. Газрын нийт албан хаагчид болон өргөдөл, гомдол хүлээн авах ажилтны мэдээллийг газрын цахим хуудсанд

нээлттэй байршуулан, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн төлөвлөлтийн систем /ERP/-д цахим өргөдөл, гомдлын дэд системийг ашиглан, Засгийн газрын 11-11 төв, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд, Шуурхай удирдлага, зохицуулалтын төв, www.ub1200.mn цахим хуудас, smart UB, Clean UB аппликейшн, 1800-1200, бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 тусгай дугаарын утас, газрын 7777-1890 болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон тус газрын веб хуудас, хэлтэс нэгжүүдийн ажлын байр, иргэдээс санал хүсэлт авах хайрцаг, дэвтэр зэрэг эх сурвалжаар иргэд, байгууллагаас **606 өргөдөл, гомдол, санал** хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэн ажилласан.

Байгууллагын албан ёсны цахим хуудас болон нүүр номоор сурталчилсан байдал:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл болон хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг бүхий л арга хэлбэрээр шуурхай хүргэхийн зэрэгцээ бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд:

- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.
- ❖ Нийслэл болон дүүргийн Улсын бүртгэлийн газар, хэлтсүүд мэдээ, мэдээллийг шинэчлэн өөрсдийн Нүүр ном /FACEBOOK/ хуудсанд нийт **1041** удаа давхардсан тоогоор оруулсан бөгөөд нийт **962667** харилцагч зочилж, улсын бүртгэлийн хууль тогтоомж, үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг шинээр авсан байна.
- ❖ Тайлангийн хугацаанд байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлын хүрээнд 31 удаа телевизээр, 12 удаа радио болон бусад мэдээллийн сувгаар улсын бүртгэлийн үйл ажиллагаа, бүртгэлийн үйлчилгээг сурталчилан иргэд олон нийтийг **43** удаа мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.
- ❖ Тус газрын 7777-1890 тусгай дугаарын утсаар **1828**, хэлтсүүдийн лавлах утсаар **13654**, нийт **15482** иргэн, хуулийн этгээдийг мэдээ, мэдээллээр ханган ажилласан.
- ❖ “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд нийслэлийн бүх хороодоос иргэдэд тоон гарын үсэг олгож эхэлсэн тухай болон иргэдийг тоон гарын үсгээ аваарай гэсэн уриалга бүхий олны танил хүмүүсийг оролцуулсан нийт 10 шторк бэлтгэн байгууллагын албан ёсны цахим сайт, нүүр хуудсанд @Тоон гарын үсэг гэж “хаштаг” байршуулсан байна.
- ❖ **Ёслолтой бүртгэлийн чиглэлээр:** Иргэний баримт бичгийг ёслолтой гардуулж, байгууллагын үйл ажиллагааг сурталчилан ажиллах хүрээнд гэрлэлтийн **231** бүртгэл, **101** шинэ төрсөн хүүхдийн төрсний гэрчилгээ, 16 насанд хүрч шинээр иргэний үнэмлэх авч байгаа ерөнхий боловсролын дунд сургуулийн **764** сурагчдад иргэний үнэмлэхийг ёслолтой гардуулах

арга хэмжээг 6 удаа, нийт **1096** бүртгэлийг ёслолтой гардуулж улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилсан байна

2.11.2 Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал:

Энэ хүрээнд <https://www.niislel@burtgel.gov.mn> байгууллагын цахим хуудаст хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, Байгууллагын бүтэц, орон тоог баталсан тушаал, баталсан орон тоонд ажиллаж байгаа албан хаагчдын мэдээлэл, албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан тухай тушаал, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам, албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм, сул орон тооны тухай мэдээлэл болон хүний нөөцтэй холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

2.11.3 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал:

Газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг байршуулан ажиллаж байна.

Тус байгууллагын шилэн дансанд <https://www.niislel@burtgel.gov.mn/> нийт 11 удаа 133 мэдээллийг байршуулсан.

2.11.4 Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал:

Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэлийг тухай бүр шинэчлэн байршуулж хэвшсэн.

2.11.5 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал:

Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг байгууллагын албан ёсны сайтад байршуулсан.

2.12 Улсын бүртгэлийн байгууллагын “үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд:

“Байгууллагын үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг хангах, өдөр тутам хяналт тавих, тайлагнах зэрэг чиг үүргийг тухайн нэгжийн хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч нар хэрэгжүүлж, сар бүр НУБГ_СТ_1, НУБГ_СТ_2 маягтаар хэрэгжилтийг дүгнэж тус газарт “Дүгнэх хуудас”-аар ирүүлж хэвшсэн.

Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдээс ирүүлсэн “ДҮГНЭХ ХУУДАС”-ыг Нийслэлийн хэмжээнд нэгтгэн дүгнэхэд **97,5** хувийн үзүүлэлттэй байна.

Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/700 дугаар тушаалаар байгуулагдсан улсын бүртгэлийн байгууллагын “Брендбүүк” бүтээх ажлыг судлах, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, төлөвлөгөө боловсруулан Төрийн байгууллагуудын брендбүүк бүтээсэн

туршлагатай маркетингийн компаниудын судалгаа, гадаад, дотоод харилцагчдын судалгаа, батлагдсан брендбүүк бүхий төрийн байгууллагуудын судалгаа хийж, танилцуулга бэлдэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргад хүргүүлэв. Дотоод харилцагчдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор 9 асуулга бүхий судалгаа явуулж, уг судалгаанд системийн хэмжээний нийт ажилтан, албан хаагчдын 62.2 хувь буюу 791 албан хаагч хамрагдаж, 95 хувь нь улсын бүртгэлийн брендбүүк хийх шаардлагатай гэж үзсэн байна.

- ❖ Тус газраас харилцагчийн үйлчилгээний чиглэлээр дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүдэд 3 удаа чиглэл хүргүүлсэн.


Харилцагчийн үнэлгээний систем нэвтрүүлж, үр дүнг тооцох чиглэлээр:

Албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажлын бүтээмж болон гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлэх зорилгоор Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу харилцагчдад үйлчилгээ үзүүлж буй албан хаагч нэг бүрийн цонх бүрт “Албан хаагчдын хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ авах” QR кодыг байршуулан харилцагчдаас үнэлгээ болон санал хүсэлт авч ажиллалаа.

Тайлангийн хугацаанд 1498 харилцагч үнэлгээ өгсөн байна. Үнэлгээ өгсөн байдлыг нэгжүүдээр авч үзвэл хороодод-809 буюу 54%, НҮНТ-293 буюу 19%, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүдэд-400 буюу 18.5% байна.

Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн “Нэг цонх”-ны үйлчилгээний танхимд болон хороодын нэг цонх, танхимуудад QR код байршуулсан байна.

Дээрх програмын хөгжүүлэлт, сайжруулалт хийхэд дэмжлэг шаардлагатай байгаа талаарх санал, танилцуулгыг 2022 оны 6 дугаар сард Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулж, програмын хөгжүүлэлтэд зориулан 50 сая төгрөгийн төсөв шийдвэрлүүлэн ажилласан. Мөн програмын хөгжүүлэлтийн даалгавар боловсруулан хүргүүлсэн.




ГУРАВ.УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


3.1.Иргэний улсын бүртгэл хөтлөх чиглэлээр:

Нийслэлийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар **668633** иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг газар, 9 дүүрэг болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, улсын бүртгэлийн нэг цэг, хороодоор хүргэн ажилласан байна. Үүнд:

- ❖ Иргэний гэр бүлийн бүртгэл-60785
- ❖ Шилжилт хөдөлгөөн-96365
- ❖ Иргэний үнэмлэхний бүртгэл-107646
- ❖ Үндэсний энгийн гадаад паспорт олголт-179071
- ❖ Лавлагаа олголт-224766



Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 31 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Үндэсний энгийн гадаад паспорт олгох үйлчилгээ 2021 оны мөн үетэй харьцуулахад 3 дахин ихэссэн үзүүлэлттэй байна. Энэ нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй гадаадад зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тавигдсантай холбоотой.


3.2 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх чиглэлээр:

3.3

Нийслэлийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар **231961** эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

- ❖ Анхны бүртгэл-35294
- ❖ Өмчлөх эрх шилжих гэрээ-46900
- ❖ Барьцааны гэрээ-122744
- ❖ Бусад гэрээ-1079
- ❖ Бүртгэлд өөрчлөлт оруулах-8610
- ❖ Лавлагаа, хуулбар-13596

- ❖ Тусгай болон урьдчилсан тэмдэглэлийн дүн-742
- ❖ Үрэгдүүлсэн гэрчилгээ дахин олгох-1107
- ❖ Хувийн хэрэг хаах-1889




Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2021 оны мөн үетэй харьцуулахад 15 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь банкууд зээл хаасантай холбоотойгоор буурсан байна.

3.3 Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх чиглэлээр:

Нийслэлийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар **26650** хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

- ❖ Анхны бүртгэл-4827
- ❖ Дахин авсан-1398
- ❖ Нэр олгох-4708
- ❖ Хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах-6394
- ❖ Хуулийн этгээдийн үйлчилгээ явуулах эрхийг сунгах-23
- ❖ Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой бусад бүртгэл-4678
- ❖ Лавлагаа-4622



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2022 онд иргэдэд үзүүлсэн үйлчилгээ нь 2021 оны бүртгэлээс 1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Дээрх 3 төрлийн улсын бүртгэлийн үйлчилгээний төрлөөр 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийслэлийн хэмжээнд нийт 927244 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.



Тус газрын 2022 онд иргэд, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээ нь 2021 оны мөн үеийнхээс 23 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.4 Бичиг баримтжуулах ажлын хүрээнд

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоол Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/487 дугаар захирамжийг үндэслэн Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгмийн олон талт үйлчилгээнд хамруулах зорилгоор иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах ажлын хүрээнд дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан хөдөлмөр хийлгэх газар, Улаан загалмайн нийгэмлэг, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, дүүргийн хөдөлмөр халамжийн газар, банк бус санхүүгийн байгууллага зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан.

Тайлангийн хугацаанд зорилтот бүлгийн болон бичиг баримтгүй 696 иргэнийг бичиг баримтжуулан ажиллалаа.



3.5. Улсын бүртгэлийн нэгдсэн архивын чиглэлээр:

Архивын хэлтэс нь төрөөс архивын үйл ажиллагааны талаар явуулж буй бодлого чиглэлийг нийслэлийн бүртгэлийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааны явцад бий болсон баримтыг архивт хүлээн авах, нөхөн бүрдүүлэлт хийх, эмхлэн цэгцлэх, нягтлан шалгах, журмын дагуу хадгалж хамгаалах, ашиглуулах, лавлагаа мэдээлэл, хуулбар олгох, данс, тоо бүртгэл хөтлөх, архивын ажлын хяналт шалгалт хийх, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүдийн архивын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Нийт 195647 баримт иргэний баримтын архивт хүлээн авснаас дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс 141703 маягтыг дагалдах хуудастай, орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтсээс 53944 иргэний хувийн хэргийг нэрсийн жагсаалттай нь

тус тус тулгаж хүлээн авч, 2021 онд дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд хөтлөгдсөн бүртгэлийн эх нотлох баримт 545 боть хадгаламжийн нэгж, нас барсны бүртгэлийн дэвтэр 6, АМ-7 маягтын 10 боть баримтыг архивт хүлээн авч, нягтлан шалган, ангилан төрөлжүүлсэн.

2022 оны 2 дугаар сарын 18-ны өдөр тус газрын даргаас төвийн 6 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нарт хугацаатай үүрэг даалгавар өгч, бэлтгэл ажлыг ханган 02 дугаар сарын 20-ны өдрөөс 3 дугаар сарын эхний долоо хоногт багтаан үл хөдлөх эд хөрөнгийн “Ү” дугаарын эх нотлох баримт болох 01-5000 хүртэлх хувийн хэргийг нүүлгэн шилжүүлж, санд байрлуулах ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосны дагуу ерөнхий зохион байгуулалтыг хэлтсийн ахлах мэргэжилтэн ахалж, эх нотлох баримтыг дугаарлан хайрцаглаж, бүртгэлжүүлэх ажлыг дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч, судлаач архивч нар хариуцан хяналт тавьж ажилласан.

Энэ оны 2 дугаар улиралд Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн байранд засвар орсонтой холбогдуулан нягтаршуулсан сэйфэнд багтахгүй байгаа үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн Ү дугаарын 4000 ширхэг хувийн хэргийг нэмж нүүлгэсэн. Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 5000 ширхэг хувийн хэргийг 85 хайрцагаар багцлан, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 10000 ширхэг хувийн хэргийг 309 хайрцагаар багцлан, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 10004 ширхэг хувийн хэргийг 159 хайрцагаар багцлан, Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 26004 ширхэг хувийн хэргийг, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 10003 ширхэг хувийн хэргийг 152 хайрцагаар багцлан, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн “Ү” дугаарын 10000 ширхэг хувийн хэргийг 375 хайрцагаар багцлан нийт 71011 ширхэг дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн архивт байршуулсан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримт болох “Ү” дугаарын хувийн хэргийг нүүлгэн шилжүүлж, санд өрж байрлуулав.



2022 оны 10/05 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэл зөвлөмжийн дагуу тус газрын даргын 2022 оны А/02 дугаар тушаалыг хэрэгжүүлж, хадгалах хугацаа дууссан 686564 хуудас баримтыг устгах ажлыг хууль тогтоомжид заасан хугацаанд 800000 төгрөгийн зардал төсөвлөж Ажлын хэсгийг дүүрэг тус бүрт байгуулан хийж гүйцэтгэсэн.



Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 03 дугаар сарын 21-ний өдрөөс 4 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааг шалгах шалгалтын бүрэлдэхүүнд хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, ахлах архивч нар ажиллаж Архивын баримтын бүрдүүлэлт, үндсэн баримт хүлээлцсэн байдал, дагалдах жагсаалт, хугацаандаа өгсөн эсэх, архивт улсын бүртгэлийн эх нотлох баримтын хадгалалт хамгаалалтын байдалд авч хэрэгжүүлсэн ажлыг газар дээр нь очиж шалгав. Шалгалтын үр дүнгийн талаар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нарт зөвлөмж өгч, цаашид анхаарах асуудал, зөрчил дутагдлын талаар чиглэл өгсөн. Шалгалтын дүнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримт хадгалах хувийн хэргийн А4 цаасан хайрцаг дуусч тасран, баримтыг задгай хадгалж байгааг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газарт мэдэгдэж, яаралтай худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг уламжилсаны дагуу энэ оны 6 дугаар сард цаасан хайрцагийг бүх дүүрэгт хүргүүлсэн. Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст ахлах архивч ажлын 1 өдөр очиж мэргэжил аргагүйгээр ханган ажилласан. Түүнчлэн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн архивын байрны хадгалалтын даац хэтэрч, зориулалтын бус байранд эх нотлох баримт хадгалж байгааг илрүүлж, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, ахлах архивч нар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Дэд дарга Т.Атармаад нөхцөл байдлыг газар дээр нь үзүүлж танилцуулсан.

Түүнчлэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/244 дугаар тушаалаар улсын бүртгэлийн байгууллагын төв, орон нутгийн улсын бүртгэлийн архивт хадгалагдаж байгаа эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт авагдсан нотлох баримтад дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд газрын дарга ажиллаж дүүргүүдийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн баримтын архивт тооллого зохион байгуулав.

Энэ үеэр Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, Архивын хэлтэс бүрэн хангалттай буюу Маш сайн үнэлгээ авсан.

Тус хэлтэс нь байгууллагын “БАРИМТ НЯГТЛАН ШАЛГАХ КОМИСС”-ыг удирдаж, комиссын хурлыг 3 удаа зохион байгуулж, үлгэрчилсэн болон салбарын жагсаалтад санал боловсруулан хэлэлцэж дээд газраа хүргүүлэх, байгууллагын архивын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн судлаач архивч нарт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, баримт устгах ажлыг удирдлагаар хангаж зохион байгуулах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Мөн байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-д хэлтсийн дарга, ахлах архивч

гишүүнээр ажиллаж үндсэн хөрөнгийн тооллого, акталж устгах ажилд хөндлөнгийн хяналт тавьж ажиллаж байна.

Мэргэшсэн албан хаагч бэлтгэх зорилгоор газрын нийт албан хаагчдаас сургалтын агуулга хэлбэрийг тодорхойлох судалгааг авч нэгтгэснээр байгууллагын сургалтын модульд саналаа боловсруулан өгч, мэргэшлийн үнэмлэх олгох “Архив албан хэрэг хөтлөлтийн анхан шатны сургалтад 3 албан хаагч хамрагдаж “АРХИВЧ” мэргэжлийн үнэмлэх авч, сургалтын зардлыг байгууллагаас олгож, суралцах боломж олгосон.

Мөн Төрийн архивын албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх, ажилтнуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, баримт бичгийн эмх цэгц, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор Архивын ерөнхий газраас мэргэжилтэн урьж, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газраас зохион байгуулсан “Төрийн албан хэрэг хөтлөлт” сэдэвт сургалтад нийслэлийн нийт судлаач архивч нар хамрагдсан.

ДӨРӨВ. НӨХӨН СОНГУУЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

Багахангай, Сонгинохайрхан дүүрэгт явагдах нөхөн сонгууль:

Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 21-ний А/04 дугаар “Нөхөн сонгуулийн тов зарлах тухай” тогтоол, Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 24 дүгээр тойрогт нөхөн сонгууль товлон зарласантай холбогдуулан Газрын даргын 2022 оны Б/27 дугаар тушаалаар Багахангай, Сонгинохайрхан дүүрэгт ажиллах 5 итгэмжлэгдсэн ажилтны тушаалыг гаргаж, итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах албан хаагчдаас нууцын баталгаа гаргуулж, гэрээ байгуулах, Итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах ажилтан нарт эрх зүйн сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулах, сонгуулийн хууль тогтоомжид заасны дагуу сонгогчийн нэрийн жагсаалтыг хэвлэж, хэсгийн хороонд сонгогчийн нэрийн жагсаалтыг хүргүүлэх ажлыг зохион байгуулах, Сонгогчийн нэрийн жагсаалтад хуульд заасны дагуу өөрчлөлтийг тусгаж, лавлагаа хэвлэх ажлыг зохион байгуулах, /хянах, хэвлэх/, Сонгуулийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, аюулгүй байдлыг хангах цагдаагийн албан хаагч, нэр дэвшигч, нэр дэвшигчийн менежер, шадар туслагчийн сонгогчийн шилжих хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн ажиллах зэрэг ажлуудыг төлөвлөн зохион байгуулж ажилласан. Тус газраас 2022 оны 6 дугаар сарын 19-ний өдөр ажиллах шуурхай багийн А/17 тушаалыг гарган 2 дүүрэгт сонгуулийг амжилттай зохион байгуулсан.

ТАВ.КОВИД ЦАР ТАХЛЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД:

Засгийн газрын 2022 оны 66 дугаар тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн цуцалж, халдварын тархалтын “Шар түвшин”-д шилжсэнтэй холбогдуулан бүх нийтийн бэлэн болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажилласан тухай мэдээллийг авахыг зогсоосон.

Бүх нийтийн бэлэн болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажилласан тухай мэдээллийг дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсээс өдөр бүр авч нэгтгэж,

Улсын бүртгэлийн ерөнхий газрын хариуцлагатай жижүүр, Нийслэлийн онцгой комиссын Шуурхай штабт тогтсон цагт хүргүүлж ажилласан бөгөөд нийт 34 удаа хүргүүлсэн байна.

Мөн үүнээс гадна Ковид-19 цар тахалтай холбоотой нийт 8 төрлийн мэдээ, санал, судалгаа, илтгэх хуудсыг боловсруулж, холбогдох газар, албан тушаалтанд 25 удаа хүргүүлсэн байна.

ЗУРГАА. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Нийслэлийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах, ажиллах журам батлах тухай” А/247 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 12 дугаар заалтад гамшиг ослын үед орон гэргүй болсон иргэдийг бүртгэх, сураггүй алга болсон иргэдийн мэдээллийг гаргаж удирдлагад танилцуулах, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулах Нийслэлийн гамшгаас хамгаалах Бүртгэл мэдээллийн албаар тус газрыг, 2 дугаар хавсралтын 16 дугаар заалтад гамшиг ослын үед иргэний бүртгэл, судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах, хуулийн этгээд, иргэнд шаардлагатай лавлагаа, мэдээлэл гаргаж өгөх Мэргэжлийн ангиар дүүргүүдийн Улсын бүртгэлийн хэлтсийг тус тус томилж баталсан.

Энэ хүрээнд Нийслэлийн онцгой комиссын 2022 оны 02 дугаар сарын 8-ны өдрийн 36 дугаар зөвлөмжийн дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах 17 заалт бүхий бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан батлан, хэрэгжилтийг хангаж ажиллав.

Төлөвлөгөөний дагуу Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 6 төлөвлөгөө, 4 тушаал, 1 чиглэл, хөтөлбөр боловсруулж, газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав.

Газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/13 дугаар тушаалаар “Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх” ажлын хэсэг байгуулан Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж, тайлан боловсруулсан. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгтэй холбогдуулан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нарт 1/190 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлж мэргэжил арга зүйгээр ханган ажиллав.

Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс буюу Мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулав.



Нийслэлийн онцгой байдлын газрын галын байцаагчаас 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажиллав.



Нийслэлийн онцгой байдлын газартай хамтран 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдөр “Гамшгаас хамгаалах бүртгэл мэдээллийн албаны томилгоот бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг олгох” сургалт зохион байгуулж, сургалтад газрын 24, Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн 16, нийт 40 албан хаагч хамрагдлаа.



Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт оролцох бүрэлдэхүүний нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, бэлэн байдлын үүргэвчийг жигдрүүлэв.



Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/59 дүгээр захирамжаар баталсан хуваарийн дагуу Бүртгэл мэдээллийн албаны нийт бүрэлдэхүүн, орон тооны бус штабын бэлтгэл бэлэн байдалд Нийслэлийн Засаг даргын нэрэмжит үзлэг, шалгалт 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулагдаж, тус газрын 27 албан хаагч оролцлоо.



Уг үзлэгээр хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих зүйл, хувцасны жигдрэлт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, сургалт, мэдээллийн сангийн бэлтгэл, бэлэн байдал зэрэг 16 үзүүлэлтээр Нийслэлийн онцгой комиссын орлогч даргын 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр баталсан удирдамжаар үзлэг зохион байгуулах ажлын хэсэг шалгалт хийж, 91% буюу “А” “Дүүрэн хангалттай” үнэлгээтэй үнэлэгдсэн.

ДОЛОО. ШИНЭ ХОРОО БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний 12/36 тоот "Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай" тогтоолын дагуу Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт шинээр 33 хороо байгуулагдахаар болсон. Үүнтэй холбоотойгоор иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор шинээр байгуулагдсан 33 хорооны төрийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах, иргэдийн хаягийн мэдээлэл, хуулийн этгээдийн болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлыг зохион байгуулахтай холбоотой зардлын тооцоог гарган Нийслэлийн Засаг даргын А/261 тоот “Засаг захиргааны анхан шатны нэгж хороо байгуулагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” захирамжийг 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдөр гаргуулсан.

Тус газраас шинээр байгуулагдаж буй хороодын тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлын худалдан авах ажиллагааг 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдөр тендер

зарлан 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Тендерийн сонгон шалгаруулалтыг хийж гэрээ хийж, шинээр байгуулагдаж буй хороодод ашиглагдах компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 182408 иргэний хаягийн мэдээллийн санд өөрчлөлт оруулах иргэний үнэмлэхийн бэлдэцийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн нэмэлт санхүүжилтийн эрх нээгдэн Уг захирамжийн хэрэгжилтийг ханган 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 10986 иргэний иргэний үнэмлэх, 8 иргэний газрын гэрчилгээ, 900 иргэний үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ нийт **11894** бүртгэл хийсэн байна.



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЦЭГ БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах, иргэд, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг ойртуулах зорилтын хүрээнд “Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ”-г шинээр нэвтрүүлэн ажиллаж эхэлсэн.

Энэ онд 5 цэг /Баянзүрх дүүргийн төр захиргааны II байранд байрлах “Улсын бүртгэлийн нэг цэг”, Баянзүрх дүүргийн Жанжин клуб соёлын ордонд байрлах “Улсын бүртгэлийн нэг цэг”, Баянзүрх дүүргийн дарь эхийн 29 дүгээр хорооны байранд байрлах “Улсын бүртгэлийн нэг цэг”, Хан-Уул дүүргийн Буянт-Ухаа төвд байрлах “Улсын бүртгэлийн нэг цэг”, Чингэлтэй дүүргийн спорт хорооны байранд байрлах “Улсын бүртгэлийн нэг цэг”/-ийг шинээр нээн ажиллуулж байна.





НАЙМ. ЗОХИОН БАЙГУУЛСАН БУСАД АЖИЛ

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жендэрийн үндэсний хорооноос санаачлан хэрэгжүүлж буй "Харилцан хүндэтгэе" сарын аянд нийслэл, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон нэгдэж ажилласан. Аяны хүрээнд "ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ" нэртэйгээр "Хамт олноо хайрлан хүндэтгэе", "Гэр бүлээ харилцан хүндэтгэе", "Бие биенээ харилцан хүндэтгэе", "Ахмадуудаа харилцан хүндэтгэе", "Хүүхдүүдээ харилцан хүндэтгэе", "Бусдын хийсэн ажлыг хүндэлье", уриатайгаар оролцон нөлөөллийн ажлыг амжилттай зохион байгуулан газар, хэлтсийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан.

"Таны эрх таны оролцоо авилгад үгүй гэж хэлье" аяны хүрээнд тус газрын цахим хуудас болон хэлтсүүдийн пэйж хуудсуудаар авлигаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлж ажилласан.



Монгол Улсын Ерөнхий сайдын санаачлагаар "Илүүдэл жингүй-Эртэт Монгол" аяны хүрээнд хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж, дадал болгох зорилгоор тус аянд газар, хэлтсийн албан хаагчид идэвхтэй хамрагдсан.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын дагуу "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд өрнөж буй "Ногоон хот-Иргэний оролцоо" мод тарих аяны арга хэмжээнд улсын бүртгэлийн албан хаагчид оролцон 1540 мод тарьж ажилласан.



Иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах эрхийг хамгаалахад аж ахуй нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын ерөнхий менежерийн тушаалын дагуу “ХАВАР, НАМРЫН БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ”-ний ажлыг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд нийслэл, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүд бүгд хамрагдсан.



ЕС. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР:

1. Хууль хяналтын болон төрийн бусад байгууллагатай хуулийн хүрээнд ажлаа идэвхтэй уялдуулан хамтарч ажиллах;
2. Иргэд, хуулийн этгээдэд үзүүлж буй бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах;
3. “Улсын бүртгэлийн нэг цэг”-ийн тоог нэмэгдүүлэх
4. Анхан шатны нэгжээс үзүүлэх бүртгэлийн тоог нэмэгдүүлэх.

ХЯНАСАН: ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАЙГАЛМАА

ТАЙЛАН БИЧСЭН:МЭРГЭЖИЛТЭН

Б.ЦЭДЭН

